

## 36 ОН ЦАГИЙН БОЛЗОЛГҮЙ ЕРӨӨЛ

### 36.1 Шинэ Израилийг байгуулах

<sup>3</sup>ЭЗЭН түүнд холоос үзэгдэн “Би чамайг үүрдийн хайраар хайрласан. Тийм учраас Би чамайг хайр энэрлээр татсан билээ. ( Иеремиа 31:4 АБ 2004 )

<sup>13</sup>Би ард түмнүүдээс тэднийг гаргаж, улсуудаас тэднийг цуглуулж, тэднийг уугуул нутагт нь аваачна. Израилийн уулс, урсгалуудын дэргэд болон тэр нутаг дахь хүмүүс оршин буй хамаг газруудад Би тэднийг тэжээх болно. ( Езекиел 34:13 АБ 2004 )

[ ] Таньд өгсөн Түүний үгэнд итгэдэг үү?

[ ] Та энэ ертөнцийн гажуудсан ёс заншилд уруу татагддаг уу?

[ ] Та Бурханы зөв шударга, хардалтыг мэдэх үү ?

Үндэстэний гэнэтийн төрөлт

<sup>7</sup>Тэр эмэгтэй дуншиж өвдөхөөсөө өмнө төрлөө. Тэр зовоогүй атлаа хүү төрүүлэв. <sup>8</sup>Хэн ийм юм сонссон бэ? Хэн ийм юм үзсэн бэ? Ганц өдөрт газар бий болж чадах уу? Ганц мөчид л үндэстэн бий болж чадах уу? Сион дуншиж эхэлмэгц, тэр эмэгтэй мөн хөвгүүдээ төрүүлэв. ( Исаиа 66:7-8 АБ 2004 )

<sup>14</sup>ЭЗЭН тунхаглаж байна “Тийм учраас үзэгтүн, “Израилийн хөвгүүдийг Египет нутгаас гаргасан ЭЗЭНий амьд буйгаар тангараглая” гэж хэлэгдэхгүй, <sup>15</sup>харин “Израилийн хөвгүүдийг хойд зүгийн нутгаас болон Өөрөө тэднийг хөөн зайлуулж аваачсан бүх орнуудаас авчирсан ЭЗЭНий амьд буйгаар тангараглая” гэж хэлэгдэх өдрүүд ирж байна. Учир нь Би тэдний эцэг өвгөдөд өгсөн тэдний өөрсдийн нутагт тэднийг авчрах болно. ( Иеремиа 16: 14-15 АБ 2004 )

<sup>36</sup>Тэгээд та нарын эргэн тойронд үлдсэн үндэстнүүд нь ЭЗЭН Би нурсан газруудыг барьж засан, хоосорч үгүйрсэн газруудад тарьсан гэдгийг мэдэх болно. ЭЗЭН Би үүнийг айлдсан, үүнийг үйлдэх болно”. ( Езекиел 36:36 АБ 2004 )

<sup>22</sup>Би тэднийг тэр газарт, Израилийн уулс дээр нэгэн үндэстэн болгоно. Нэг л хаан тэдний бүгдийнх нь хаан байх болно. Тэд хойшид хоёр үндэстэн болохгүй, тэд цаашид хоёр хаанчлалд хуваагдахгүй. ( Езекиел 37:22 АБ 2004 )

## 36.2 Үргэлжлэх хаант улс

<sup>3</sup>“Би Өөрийн сонгосон нэгэнтэй гэрээ байгуулсан. Би Өөрийн зарц Давидад тангарагласан, <sup>4</sup>Би чиний үрийг мөнхөд тогтоож, Чиний хаан ширээг бүх үеийнхэнд байгуулна ( Дуулал 89:3-4 АБ 2004 )

<sup>28</sup>Би Өөрийн хайр энэрлээ түүний төлөө мөнхөд хадгалж, Өөрийн гэрээг ч түүнд батжуулна. <sup>29</sup>Ингээд Би түүний үр удмыг мөнхөд тогтоож, Түүний сэнтийг тэнгэрийн өдрүүд мэт болгоно. ( Дуулал 89:28-29 АБ 2004 )

<sup>26</sup>Би танай шүүгчдийг анхных шиг нь, мөн зөвлөхүүдийг чинь эхнийх шиг нь сэргээнэ. Үүний дараа чи шударга хот, итгэлт хот гэж нэрлэгдэнэ” ( Исаиа 1:26 АБ 2004 )

<sup>10</sup>Тийнхүү Түүний надад тушаасан ёсоор би эш үзүүлсэнд амьсгал тэдэнд орж, тэд амьд болов. Үлэмж их цэргүүд хөл дээрээ босоцгоов. <sup>11</sup>Тэгээд тэр надад -Хүний хүү, эдгээр яснууд бол Израилийн хамаг гэр юм. Харагтун, тэд “Бидний яс хувхайрч, бидний найдлага мөхжээ. Бид бүрмөсөн таслагдав” хэмээдэг. <sup>12</sup>Тиймийн тул, чи эш үзүүлэн тэдэнд хэл. “Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. “Харагтун. Миний ард түмэн, Би та нарын булшнуудыг нээж, та нарыг булшнуудаас чинь гаргана. Би та нарыг Израилийн газарт авчрах болно. <sup>13</sup>Миний ард түмэн, Би та нарын булшнуудыг нээж, та нарыг булшнуудаас чинь гаргасан үед та нар Намайг ЭЗЭН мөн гэдгийг мэдэх болно. <sup>14</sup>Би та нарын дотор Өөрийн Сүнсийг тавьж, та нар амилж, Би та нарыг төрөлх нутагт чинь суулгах болно. Тэгээд ЭЗЭН Би үүнийг айлдсан ба үүнийг бүтээснийг та нар мэдэх болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна”. ( Езиекел 37:10-14 АБ 2004 )

<sup>21</sup>Тэдэнд хэл. “Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. “Харагтун. Би Израилийн хөвгүүдийг очсон үндэстнүүдийнх нь дундаас авч, тэднийг зүг бүрээс цуглуулж, төрөлх нутагт нь аваачна. <sup>22</sup>Би тэднийг тэр газарт, Израилийн уулс дээр нэгэн үндэстэн болгоно. Нэг л хаан тэдний бүгдийнх нь хаан байх болно. Тэд хойшид хоёр

үндэстэн болохгүй, тэд цаашид хоёр хаанчлалд хуваагдахгүй. <sup>23</sup>Тэд хойшид өөрсдийн шүтээнүүд, өөрсдийн бузар зүйлс болон өөрсдийн аливаа гэм нүглээр өөрсдийгөө бузарлахгүй. Харин нүгэл үйлдсэн тэдний оршин сууж буй газруудаас нь тэднийг Би аварч, тэднийг цэвэрлэх болно. Тэд Миний ард түмэн болж, Би тэдний Бурхан болно. <sup>24</sup>Миний зарц Давид тэднийг захирах хаан болж, тэд бүгд ганц хоньчинтой байна. Тэд Миний зарлигаар явж, Миний тогтоолуудыг сахин үйлдэх болно. <sup>25</sup>Би Өөрийн зарц Иаковтаа өгсөн нутаг буюу та нарын өвөг дээдсийн амьдарсан тэр газарт тэд амьдрах болно. Тэд тэнд өөрсдийн хөвгүүд болон хөвгүүдийнхээ хөвгүүдтэй хамт мөнхөд амьдарна. Миний зарц Давид үүрд тэдний ноён болно. ( Езиекел 37:21-25 АБ 2004 )

<sup>20</sup>Харин Иудад үүрд мөнхөд, Иерусалимд бүх үеийн туршид хүн амьдран нутаглана. ( Иоел 3:20 АБ 2004 )

<sup>5</sup>Би бас тэднийг өөрсдийнх нь газар дээр тарина. Миний тэдэнд өгсөн газраас тэд дахин үндсээрээ таслагдахгүй” гэж чиний Бурхан ЭЗЭН айлдаж байна. ( Амос 9:15 АБ 2004 )

[ ] Израиль үндэстэн мөн адил байршилдаа удаан хугацаагаар нам гүм байсны эцэст 1948 онд үндэстэн гэж хэрхэн тунхаглагдсаныг та мэдэх үү?

[ ] Шинэ үүссэн Израиль нь харин устахгүй зөвт байдлын хот болно гэдгийг та мэдэх үү?

[ ] Таныг юу бузарлаж, хараал авчирдгийг та мэдэх үү ?

[ ] Есүс Христ та нарын хоньчин мөн үү?

[ ] Сүнс танд юу гэж хэлж байгааг та сонсож байна уу?

### **36.3 Нэг хаан**

<sup>9</sup>“Харин тэд өөрсдийн Бурхан ЭЗЭНд, мөн тэдний төлөө Миний босгох өөрсдийн хаан Давидад үйлчилнэ. ( Иеремиа 30:9 АБ 2004 )

<sup>1</sup>“Тэр үед Би Израилийн бүх ургуудын Бурхан болж, тэд Миний ард түмэн болох болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. ( Иеремиа 31:1 АБ 2004 )

<sup>38</sup>Тэд Миний ард түмэн, Би тэдний Бурхан болно. <sup>39</sup>Тэд өөрсдийн сайны төлөө болон өөрсдийн дараах үр хүүхдүүдийнхээ төлөө Надаас үргэлж эмээхийн тулд Би тэдэнд нэг зүрх, нэг замыг өгнө. (Иеремиа 32:38 АБ 2004 )

<sup>21</sup>Дараа нь Зедекиа хаан тушаал буулгаж, тэд Иеремиаг харуулын гэрийн хашаанд даалган, хотын бүх талх дуустал түүнд талхчны гудамжнаас өдөр тутам бүтэн талх өгч байв. Ингээд Иеремиа харуулын гэрийн хашаанд үлдэв. (Езекиел 37:21-22 АБ 2004 )

<sup>15</sup>“Тэр өдрүүдэд болон тэр цагт Би Давидын зөв шударга Мөчрийг гаргана. Тэрээр газар дэлхий дээр шударга ёс болон зөв шударгыг гүйцэтгэх болно. (Езекиел 33:15 АБ 2004 )

<sup>22</sup>Тэнгэрийн эрхсүүд тоологдож, далайн элс хэмжигддэггүйн адил Би Өөрийн зарц Давидын үр удмыг болон Надад үйлчилдэг левичүүдийг олон болгоно” хэмээв” гэжээ.(Иеремиа 33:22 АБ 2004 )

<sup>22</sup>тиймийн тул Би Өөрийн сүргийг аварч, тэд олз болохгүй. Би нэг хонь нөгөө хонины хоорондохыг шүүх болно. (Езекиел 34:22 АБ 2004 )

<sup>23</sup>Дараа нь Би тэдний дээр нэгэн хоньчинг буюу Өөрийн зарц Давидыг томилж, тэрээр тэднийг тэжээх болно. Тэр өөрөө тэднийг тэжээж, тэдний хоньчин болно. (Езекиел 34:23 АБ 2004 )

<sup>5</sup>Тэр өдөр түмэн цэргийн ЭЗЭН Өөрийн амьд үлдсэн хүмүүст цог жавхлант титэм, үзэсгэлэнт цэцгэн хэлхээ болж, бшүүх газар сууж буй хүнд шударга сүнс болж, дааман хаалга тийш гэдрэг довтлогч хүмүүст хүч чадал нь болно. <sup>7</sup>Тэд бас дарсанд найгаж, архинд алмайрч, тахилч хийгээд эш үзүүлэгч ч архинд найгалаа. Тэд дарсанд самуурч, архинд алмайрч, үзэгдэл үзэнгээ найган, шүүхэд согтуу байна. <sup>8</sup>Тэгээд бүх ширээ заваан бөөлжсөөр дүүрч, цэвэр газаргүй болж байна. (Исаиа 28:5-8 АБ 2004 )

Тэр өдөр Иессийн үндэс ард түмний туг мэт босож,үнийг тойрон үндэстнүүд цуглаж, алдар нь Түүний амрах газар болно. (Исаиа 11:10 АБ 2004 )

<sup>20</sup>Тэр өдөр Би Хелкиагийн хүү, Өөрийн боол Елиакимыг дуудна. <sup>1</sup>Би түүнийг чиний дээлээр хувцаслаж, чиний бүсээр бүслэн, чиний эрх мэдлийг түүнд хариуцуулна. Тэрээр Иерусалимын оршин суугчид, Иудагийн гэрийн эцэг болно. <sup>22</sup>Би түүний мөрөн дээр Давидын

гэрийн түлхүүрийг тавина. Түүнийг нээхэд хэн ч хаахгүй, түүнийг хаахад хэн ч онгойлгохгүй. <sup>23</sup>Би түүнийг хатуу газарт хадаас шиг шаана. Тэр нь эцгийнхээ гэрт алдрын сэнтий болно. <sup>24</sup>Үр удам, хойч үе ба жижиг сав суулганууд бүгдээрээ, хул аягануудаас бүх ваар савнууд хүртэл буюу эцгийнх нь гэрийн бүх алдрыг тэд түүний дээр өлгөнө. (Исаиа 22:20-24 АБ 2004 )

[ ] Таны гэр бүлийн эрхэмлэдэг зүйл бий юү?

[ ] Та энэ нь (нэг Хааныг тогтоох) эхэлэнг мэдэх үү?

[ ] Тэр өдөр израильчуудад Бурхан өгсөн амлалтуудыг та мэдэх үү ?

### 36.4 Босож, гэрэлтэх

<sup>1</sup>“Бос, гэрэлт. Учир нь чиний гэрэл ирж, ЭЗЭНий цог жавхлан чиний дээр мандаж байна. Үзэгтүн, газрыг харанхуй бүрхэн, гүн харанхуй хүмүүсийг хучсан. Гэвч ЭЗЭН чиний дээр мандан,Түүний цог жавхлан нь чиний дээр үзэгдэнэ. <sup>3</sup>Үндэстнүүд чиний гэрэл уруу, хаад нь чиний мандах туяа уруу ирнэ.<sup>4</sup>Нүдээ өргөн орчин тойрноо харагтун.Тэд бүгдээрээ цуглан, чам дээр ирж байна. Чиний хөвгүүд алс холоос ирнэ. Чиний охид гар дээр тэврүүлэн ирнэ. <sup>5</sup>Чи харж, царай чинь гэрэлтээд, чиний зүрх хөдлөн, баясна. Яагаад гэвэл далайн баялаг та нарынх болж, үндэстнүүдийн хөрөнгө чамд ирнэ. <sup>6</sup>Тэмээн сүрэг, Мидиан болон Ефагийн ботгонууд чамайг бүрхэнэ. Тэд бүгдээрээ Шебагаас ирнэ. Тэд алт хийгээд гүгэл авчран, ЭЗЭНий магтаалын сайн мэдээг тээнэ.<sup>7</sup>Кедарын бүх хонин сүрэг чам дээр цугларч, Небаиотын хуцнууд чамд үйлчилнэ. Тэд Миний тахилын ширээнд тааламжтайгаар өргөгдөн, Би Өөрийн сүр жавхлант гэрийг алдаршуулна. (Исаиа 60:1-7 АБ 2004 )

<sup>7</sup>Би Иуда болон Израилийн сайн сайхныг сэргээж, анх байсан шиг нь тэднийг дахин барьж босгоно. (Иеремиа 33:7 АБ 2004 )

<sup>15</sup>Хэдийгээр чи хаягдан, үзэн ядагдаж, хэн ч дайран өнгөрдөггүй байсан боловч, Би чамайг мөнхийн бахархал, үеэс үед баяр хөөр болгоно.

<sup>16</sup>Чи бас үндэстнүүдийн сүүгээр тэжээгдэн, хаадын мээмийг хөхнө. Тэгэхэд ЭЗЭН Би бол чиний Аврагч, чиний Чөлөөлөгч, Иаковын Хүчит Нэгэн мөн болохыг чи мэднэ. <sup>17</sup>Би чамд зэсийн оронд алт, төмрийн оронд мөнгө, модны оронд зэс, чулууны оронд төмөр авчирч, чиний төр баригчдыг амар амгалан болгон, чиний харгалзагчдыг үнэн зөв болгоно. <sup>18</sup>Чиний нутагт хүчирхийлэл,

хил хязгаарын чинь дотор эвдрэл сүйрэл дахин сонсогдохгүй. Харин чи өөрийн хана хэрмүүдийг Аврал, дааман хаалгануудаа Магтаал гэж нэрлэнэ. <sup>19</sup>Үүнээс хойш өдрөөр нар чиний гэрэл байхаа больж, сарны туяа ч чамайг гийгүүлэхээ болино. Харин ЭЗЭН чиний үүрдийн гэрэл болж, чиний Бурхан чиний алдар болно. <sup>20</sup>Хойшид чиний нар шингэхгүй, сар чинь хавиргалахгүй. Учир нь ЭЗЭН чиний үүрдийн гэрэл болж, чиний гашуудлын өдрүүд төгсөнө. <sup>21</sup>Дараа нь чиний бүх ард түмэн зөв шударга болж, газрыг мөнхөд эзэмшинэ. Тэд бол Намайг алдаршуулахын төлөө Миний тарьсан мөчир, Миний мутрын бүтээл юм. <sup>22</sup>Хамгийн өчүүхэн нэгэн нь мянга болж, хамгийн бага нэг нь хүчирхэг үндэстэн болно. ЭЗЭН Би үүнийг тухайн цагт нь яаравчлах болно”. (Исаиа 60:15-22 АБ 2004 )

<sup>14</sup>ЭЗЭН ингэж айлдаж байна. “Египетийн бүтээгдэхүүн, Кушийн наймаа, өндөр биетэй сабеанчууд чам дээр ирж, чинийх болно. Тэд чиний араас явж, гинжтэйгээ ирж, чамд бөхийн мөргөж, “Үнэхээр Бурхан чамтай хамт байна. Өөр байхгүй. Өөр Бурхан байхгүй” гэцгээнэ”. <sup>15</sup>Израилийн Бурхан Аврагч минь, үнэхээр Та Өөрийгөө нуудаг Бурхан юм. <sup>16</sup>Шүтээн хийдэг хүмүүс бүгд ичгүүрт орж, хамтдаа гутамшиг болно. <sup>17</sup>Израиль ЭЗЭНээр аврагдан Мөнхийн авралыг олно. Та нар үүрд мөнх ичихгүй, гутамшиг болохгүй. (Исаиа 45:14-17 АБ 2004 )

[ ] Эш үзүүлэгдсэн ёсоор гурав дахь ариун сүм нь Иерусалимд бий болно гэдгийг та мэдэх үү?

[ ] Таны сүм ариун бөгөөд аюулгүй байна уу?

[ ] Итгэгчид хэрэгцээгээ хаанаас бүгдийг нь хүлээн авдагийг та мэдэх үү?

[ ] Та "хүлээн зөвшөөрөгдсөн өргөл" юу гэдгийг та мэдэх үү?

[ ] Энэхүү амлалт нь ирээдүйд биелэгдэхийг та мэдэх үү?

[ ] Та бүх зүйлийг бүтээсэн Бурханы үүрд мөнхийн гэрээнд оролцохыг хүсдэг үү?

### **36.5 Та бүх гэм нүглийнхээ төлөөсийг төлсөн**

<sup>1</sup>“Миний ард түмэн тайвшрагтун, тайвшрагтун” хэмээн та нарын Бурхан айлдаж байна. <sup>2</sup>Иерусалимын зүрхэнд эелдэг ярь. Түүний хүнд хүчир үүрэг дууссан, түүний хилэнц зайлуулагдсан. Тэр бүх л нүглийнхээ төлөө ЭЗЭНий мутраас хоёр дахин хүлээн авсан гэдгийг хэлэгтүн. ( Исаиа 40:1-2 АБ 2004)

[ ] Сонгогдсон хүмүүс яагаад бусдаас илүү их төлдгийг та мэдэх үү?